

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

**Санамж:** Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Мезолитын үеийн үргэлжилсэн цаг хугацаа аль нь вэ? /1 оноо/  
 А. 800000-100000 жилийн өмнө  
 В. 12000-8000 жилийн өмнө  
 С. 8000-НТӨ III мянган  
 D. 40000-12000 жилийн өмнө  
 E. 100000-40000 жилийн өмнө

2. Дунд палеолитын үеийн гол нээлт аль нь вэ? /2 оноо/  
 А. Мал аж ахуй үүсэв. В. Газар тариалан эрхлэв. С. Гал эзэмшив.  
 D. Урлагийн үүсэл тавигдав. E. Чулуугаар анхны зэвсэг хийв.

3. Хүснэгт доторх асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олоорой /1 оноо/

Үе	Дурсгал
Палеолит	Нарийн голын бууц суурин
Неолит	?

- А. Мойлтын ам В. Цагаан агуй С. Тамсагбулагийн суурин  
 D. Ярх уулын дархны газар E. Оцон мааньт
4. Хүрлийн үе, түрүү төмрийн үеийн хүмүүс оршуулгын дурсгал үлдээдэг байжээ. Ийм зориулалттай “Дөрвөлжин булш” хэмээх дурсгал Монгол орны аль хэсгээр тархсан байдаг вэ? /1 оноо/  
 А. Баруун болон зүүн хэсгээр  
 В. Төв болон баруун хэсгээр  
 С. Зүүн болон төвийн хэсгээр  
 D. Зүүн болон хойд хэсгээр  
 E. Баруун болон хойд хэсгээр

5. Цэгийн оронд тохирох үгийг бичнэ үү  
 НТӨ II мянганд нүүдлийн мал аж ахуй бие даахтай зэрэгцэн технологийн бас нэгэн дэвшил гарсан нь.....байв. /1 оноо/  
 А.Чулуун зэвсэг В.Зээтүү С.Ялтсан хутга D.Төмөр зэвсэг E.Зүймэл зэвсэг

6. Хань улс Хүннү гүрнийг эн чацуу хүчирхэг болохыг зөвшөөрч “Энх ургийн гэрээ”-г хэдэн онд байгуулсан бэ? /1 оноо/  
 А. НТӨ 133 он В. НТӨ 206 он С. НТӨ 209 он D. НТӨ 129 он E. НТӨ 198 он

7. Хүннү гүрний үед холбогдох түүхэн үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ? /2 оноо/

1. “Энх ургийн гэрээ”-г байгуулав.  
 2. Цинь улс мөхөж, Хань улс байгуулагдав.  
 3. Хүннүгийн вангууд болох Сютү, Хүнье нар ялагдаж, Хань улсад бууж өгөв.  
 А. 2,1,3  
 В. 1,2,3  
 С. 3,2,1  
 D. 2,3,1  
 E. 1,3,2

8. Жужанчууд төрт улсаа байгуулсан 330 оныг зууны тоололд шилжүүлнэ үү /1 оноо/  
 А. IV зууны I хагас В. III зууны I хагас С. II зууны II хагас  
 D. IV зууны II хагас E. V зууны I хагас

9. Түрэгүүд Жужан улсад юугаар алба барьдаг байсан бэ? /1 оноо/  
 А. Төмөр В. Мал С. Торго D. Ангийн арьс E. Давс



10. **a,b** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? /1 оноо/  
 а. Хүннү, Сяньби, Жужан  
 б. Түрэг, Уйгур, Киргиз  
 А. Монгол болон Хятад нутагт оршиж байснаар нь  
 В. Оршин тогтносон он цагийн урт богиноор  
 С. Нийгмийн хөгжлийн түвшингийн ялгаагаар  
 Д. Угсаа гарвалын ялгаагаар  
 Е. Нүүдэлчид болон суурин иргэншлээр нь
11. Сурвалжийн мэдээнд “Хүннү, Сяньби нар мод, яс сийлэн тэмдэглэж хол ойрын хэрэг явдлаа хүмүүст улируулан уламжилсан нь түүхч, төрийн түшмэдийн тэмдэглэл мэт болсон” гэж өгүүлжээ. Энэ мэдээнд хийсэн дүгнэлтүүдээс аль нь оновчтой вэ? /1 оноо/  
 А. Хүннү, Сяньби нар Хятадтай адил төрийн түшмэдтэй байжээ.  
 В. Хүннү, Сяньби нар мод сийлэхдээ гаргуун байжээ.  
 С. Хүннү, Сяньби нар бичиг үсэгтэй байсан бөгөөд хэрэг явдлаа тэмдэглэн үлдээдэг байжээ.  
 Д. Хүннү, Сяньби нарын түүхийг Хятад түүхчид тусгайлан судалдаг байжээ.  
 Е. Хүннү, Сяньби нар мод, ясан сийлбэрээр алдартай байжээ.
12. Уйгур улсад бурхны шашин дэлгэрч байсан боловч, Уйгурын хаад ямар шашныг ивээлдээ авч байсан бэ? /1 оноо/  
 А. Бөөгийн шашин                      В. Манихейн шашин                      С. Исламын шашин  
 Д. Христийн шашин                      Е. Бурхны шашин
13. Монгол-Татар хоёр ханлигуудын хоорондын зөрчлийн шалтгаан аль нь вэ? /1 оноо/  
 А. Шашны зөрчлийн улмаас  
 В. Татарууд Монголчууд биш учраас  
 С. Мал маллахад тохиромжтой бэлчээр нутгийн төлөөх тэмцэл  
 Д. Татарууд Монголчуудад дургуй байсан учраас  
 Е. Татарууд хоёр хуваагдсан учраас
14. Монгол улсын хаадыг он цагийн дараалалд зөв оруулсан нь аль вэ? /2 оноо/  
 А. Хабул, Хотула, Амбагай Тэмүжин  
 В. Амбагай, Хотула, Есүхэй, Хабул  
 С. Хотула, Тэмүжин, Хабул, Амбагай  
 Д. Хабул, Амбагай, Хотула, Тэмүжин  
 Е. Тэмүжин, Амбагай, Хабул, Хотула
15. Монгол аймаг улсуудыг газар нутагтай нь тохируулна уу /2 оноо/  
 1. Татар аймаг                              а. Хөлөн, Буйр нуурын сав газраар  
 2. Хэрэйд улс                              б. Цагаан хэрмийн хойгуур  
 3. Онгуд                                      с. Туул, Орхон голын савд  
 А. 1с, 2b, 3а                              В. 1с, 2а, 3b                              С. 1а, 2b, 3с  
 Д. 1b, 2с, 3а                              Е. 1а, 2с, 3b
16. Чингис хаанд нэгдэхээс дургүйцсэн Тайчууд, Мэргид, Хатагин, Салжиуд нар хэдэн онд Жамухыг “Гүр” хаанд өргөмжилсөн бэ? /1 оноо/  
 А.1201 он                      В.1206 он                      С.1203 он                      Д.1189 он                      Е.1179 он
17. Их Монгол улсын том түмний ноёдыг түмэнтэй нь зөв тохируулсныг олно уу. /1 оноо/  
 А. Баруун түмэн-Мухулай, Төвийн түмэн-Боорчи, Зүүн түмэн-Хорчи, Ойн түмэн-Наяа  
 В. Баруун түмэн-Наяа, Төвийн түмэн-Боорчи, Зүүн түмэн-Хорчи, Ойн түмэн-Мухулай  
 С. Баруун түмэн-Хорчи, Төвийн түмэн-Мухулай, Зүүн түмэн-Боорчи, Ойн түмэн-Наяа  
 Д. Баруун түмэн-Боорчи, Төвийн түмэн-Наяа, Зүүн түмэн-Мухулай, Ойн түмэн-Хорчи  
 Е. Баруун түмэн-Боорчи, Төвийн түмэн-Мухулай, Зүүн түмэн-Наяа, Ойн түмэн-Хорчи



18. Монголын Их Юань улсын нийслэл хотуудыг сонгоно уу. /1 оноо/  
 А. Марага, Тебриз В. Султание, Хархорум С. Дайду, Шанду  
 D. Аксу, Карши E. Шанду, Багдад
19. Монголын Цагадайн улсын газар нутгийг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/  
 А. Армян, Гүрж, Турк, Афганистаны баруун хэсэг  
 В. Или голын сав, Долоон гол, Кашгарын нутаг буюу хуучин Хар Хятан  
 С. Хятад, Солонгос, Өмнөд Азийн орнууд  
 D. Эрчис мөрөн, Дунай мөрний доод урсгал, Кавказын нуруу  
 E. Иран, Ирак, Сирийн хойд хэсэг
20. Тогоонтөмөр хаан хэзээ, хаана нас барсан бэ? /1 оноо/  
 А. 1372 онд Шанду хотод В. 1368 онд Дайду С. 1374 онд Хархорум  
 D. 1370 онд Инчан /Барс/ E. 1388 онд Буйр нуурын ойролцоо
21. Батмөнх даян хааны үеийг сурвалжид “Гар газар, хөл хөсөр болов” гэж тэмдэглэсний учир юу вэ? /2 оноо/  
 А. Тухайн үеийн нийгмийн амьдрал илүү хямралд орсон үе  
 В. Монголд шарын шашин дэлгэрсэн үе  
 С. Мин улсын довтолгоо эрчимжиж байсан үе  
 D. Монголын дотоодын тэмцэл улам гүнзгийрч байсан үе  
 E. Монголын дотоодын хямрал нэг хэсэгтээ зогссон үе
22. XV-XVI зууны үеийн Зүүн Монголын хааны шууд захиргаанд байдаг, зүүн гурван түмэнг зөв ялгасан хувилбар аль нь вэ? /2 оноо/  
 1.Ордос 2. Цахар 3. Юншээбү 4. Түмэд 5. Халх 6. Урианхай  
 А. 2, 5, 6  
 В. 1, 3, 4  
 С. 5, 1, 3  
 D. 6, 1, 3  
 E. 3, 4, 5
23. Батмөнх даян хааны үед Халх түмэн нь Арын 7 отог, Өврийн 5 отгоос бүрдэж байсан ба Өврийн 5 отгийг түүний хөвгүүдээс хэн нь өвлөн захирч байсан бэ? /1 оноо/  
 А. Алчуболд В. Гэрсэнз С. Агваржин  
 D. Боди-Алаг E. Гүнбилэг
24. **Далай лам:** Өдгөө шарын шашны тэргүүнээр XIV Далай лам Данзанжамц заларч буй бөгөөд 1989 онд Нобелийн энх тайвны шагнал хүртсэн юм. Далай ламын бүх дүр Монголын түүхтэй ямар нэгэн сэжмээр холбогддог билээ. Тэгвэл Монголоос тодруулсан IV Далай ламын нэр хэн бэ? /1 оноо/  
 А. Содномжамц В. Занабазар С. Намхайжамц  
 D. Ёндонжамц E. Нэйж тойн
25. Эрдэнэ зуу хийдийг хэн, хэзээ байгуулсан бэ? /2 оноо/  
 А. 1748 онд Агваанжамбалданзан  
 В. 1577 онд Алтан хан  
 С. 1592 онд Нэйж тойн  
 D. 1586 онд Абтай сайн хан  
 E. 1648 онд Зая бандида Намхайжамц
26. Дараах ойлголтуудыг утгаар зөв харгалзуулна уу? /2 оноо/  
 1. Тод үсэг a. 1686 он  
 2. Али гали үсэг b. 1648 он  
 3. Соёмбо үсэг c. Аюуш гүүш  
 А. 1с, 2а, 3b  
 В. 1а, 2b, 3с  
 С. 1а, 2с, 3b  
 D. 1b, 2с, 3а  
 E. 1b, 2а, 3с



27. 1636 онд Өвөр Монголын ноёдын чуулган хаана, хэнийг Өвөр Монголын хаанд өргөмжилсөн бэ? /1 оноо/  
 А. Хөх нуурт Энх-Амгаланг  
 В. Долоон нуурт Энх-Амгаланг  
 С. Бээжинд Абахайг  
 D. Бээжинд Нурхачийг  
 E. Мүгдэнд Абахайг
28. 1655 онд өөрийн дүүгээ Манжийн хааны ордонд барьцаанд явуулсан хан хэн бэ /2оноо/  
 А. Гомбодорж В.Шолой С. Чахундорж D. Субадай E. Норов
29. Манж-Оросын “Нэрчү”-гийн гэрээгээр Орос улс Эрхүү, Түнхэний шивээ орчмын нутгийг хүн амын хамт харьяандаа оруулжээ. Уг гэрээ хэдэн онд болсон бэ? /1 оноо/  
 А. 1727 онд В. 1607 онд С. 1689 онд D. 1771 онд E. 1681 онд
30. 1646 онд харьяат нараа дагуулан Халхын сэцэн хан Шолойг түшихээр ирсэн хүн хэн бэ? /1 оноо/  
 А. Дэгдээхэй мэргэн ахай В. Сөнидийн Тэнгис ван С. Доржжав  
 D. Хо өрлөг E. Аюук хаан
31. XVII-XVIII зуунд Монгол улс тусгаар тогтнолоо алдсан гадаад шалтгаануудаас аль нь **ИЛҮҮЦ** вэ? /2 оноо/  
 А. Мин улсын хагалган бутаргах бодлого  
 В. Монголын их хааны сүр хүч буурсан учир  
 С. Хойд талаас Орос улсын түрэмгийлэл  
 D. Мин улсын Монголын ноёдыг дэмжих бодлого  
 E. Зүүн урдаас Хойт Алтан улсын заналхийлэл
32. Манжийн эсрэг Халх Монголд гарсан бослого тэмцэл хэрхэн эхэлсэн бэ? /1 оноо/  
 А. Амарсанаа цэргээ удирдаж бослого гаргаснаар  
 В. Манжийн цэргийн жанжинг хороосноор  
 С. Чингүнжав дайны талбараас босож, нутгийн зүг явснаар  
 D. Сэвдэнбалжирыг Бээжинд дуудаж гэрийн хорионд хийснээр  
 E. Манжийн цэрэг дайрч орж ирсэнээр
33. Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл хөдөлгөөнүүдийг он цагийн зөв дараалалд оруулсан хариултыг сонгоно уу /2 оноо/  
 1. Тогтох тайжийн удирдсан бослого  
 2. Лувсанданзангийн удирдсан бослого  
 3. Онолтын удирдсан бослого  
 А. 2, 1, 3  
 В. 1, 2, 3  
 С. 3, 2, 1  
 D. 2, 3, 1  
 E. 3, 1, 2
34. 1911 оны хувьсгалаар Жавзандамба хутагтыг Монгол улсын хаанд залахдаа ямар цол өргөмжилсөн бэ? /1 оноо/  
 А. Монгол улсын шашин төрийг хослон баригч наран гэрэлт Богд хаанаар  
 В. Монгол улсын хэмжээгүй эрхт хаанаар  
 С. Хэмжээт цаазат шашин төрийг хослон баригч Богд хаанаар  
 D. Монгол улсын их хаанаар  
 E. Монгол улсын Түмэн наст Их хаанаар
35. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон чулуун нүүрсний орлогын хэдэн хувийг татварлах болсон бэ? /1 оноо/  
 А. 5-10% В. 10-15% С. 10-20% D. 20-50% E. 30-50%
36. Хужирбуланд цэргийн сургуулийг хэдэн онд байгуулсан бэ? /1 оноо/  
 А. 1914 он В. 1915 он С. 1918 он D. 1913 он E. 1912 он



37. 1911 онд Монголчууд тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан билээ. Уг оныг билгийн тоололд шилжүүлнэ үү? /2 оноо/

Доорх өгөгдлийг ашиглаж бодоорой.

Аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга	Махбодь жил	Гал	Шороо	Төмөр	Ус	Мод
Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ тухайн аргын оноос 1026-г хасч, гарсан ялгаврыг 60-д хуваасны бүхэл үлдэгдэл нь олох билгийн жилийн дугаар бөгөөд ноогдвор дээр 1-ийг нэмбэл олох билгийн жилийг харьяалах жарны дугаар гарна. Хүснэгтэд буй дугаараар билгийн жил хийгээд түүний махбодыг олно.	Туулай	1	13	25	37	49
	Луу	50	2	14	26	38
	Могой	51	3	15	27	39
	Морь	40	52	4	16	28
	Хонь	41	53	5	17	29
	Бич	30	42	54	6	18
	Тахиа	31	43	55	7	19
	Нохой	20	32	44	56	8
	Гахай	21	33	45	57	9
	Хулгана	10	22	34	46	58
	Үхэр	11	23	35	47	59
	Бар	60	12	24	36	48

- A. XIV жарны модон гахай жил  
 B. XVI жарны шороон тахиа жил  
 C. XVII жарны шороон бич жил  
 D. XV жарны төмөр гахай жил  
 E. XV жарны модон бар жил
38. Ардын засгийн газрын бүтцийг зөв тохируулсан нь аль вэ? /2 оноо/  
 A. Гадаад яам-С.Данзан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Пунцагдорж  
 B. Гадаад яам-С.Данзан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Лосол  
 C. Гадаад яам-Д.Бодоо, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Н.Магсаржав  
 D. Гадаад яам-С.Данзан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Догсом  
 E. Гадаад яам-Х.Чойбалсан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Чагдаржав
39. Ардын засгийн газрын анхны бага сургууль хэдэн онд байгуулагдсан бэ? /1 оноо/  
 A. 1923 он B. 1925 он C. 1921 он D. 1924 он E. 1922 он
40. Ардын засгийн газраас 1922.01.25-нд “Эзэн хамжлагын харилцааг халах” түүхэн шийдвэр гаргасан. Энэ шийдвэрийн гол ач холбогдол аль нь вэ? /2 оноо/  
 A. Социализмыг байгуулах анхны алхам болсон.  
 B. Ард олныг нийгмийн хүлээс, ноёдын мэдлээс салгаж чөлөөлсөн.  
 C. Улс орон цөөн хүний эрх мэдлээс ангижирсан.  
 D. Засгийн бүх эрх ард түмний гарт бүрэн шилжсэн.  
 E. Хамжлагад байсан бүх хүн баяжсан.
41. VIII Богд хаан хэдэн онд таалал төгссөн бэ? /1 оноо/  
 A. 1928 он B. 1926 он C. 1923 он D. 1924 он E. 1921 он
42. 1924 оны Үндсэн хууль боловсруулсан комиссын гишүүдийг олно уу. /1 оноо/  
 A. Б.Цэрэндорж, Ж.Цэвээн  
 B. Ж.Цэвээн, Ч.Бат-Очир  
 C. Ч.Бат-Очир, Х.Чойбалсан  
 D. Э.Ринчино, С.Данзан  
 E. Н.Магсаржав, Х.Чойбалсан
43. 1932 оны 06-р сарын 29-30 хуралдсан МАХН-ын ТХ, хянан байцаах Төв Комиссын хамтарсан III бүгд хурлаар баталсан “Шинэ эргэлтийн бодлого”-ын ерөнхий агуулга аль вэ? /1 оноо/  
 A. Зүүнтний алдаатай бодлогын уршгаар бий болсон сөрөг үр дагаварыг засах.  
 B. Эдийн засгийг сэргээн хөгжүүлэх  
 C. Төрийн байгууламжийг өөрчлөх  
 D. Улс орны батлан хамгаалах хүчийг нэмэгдүүлэх  
 E. Төр намын байгуулгыг урвагчдаас цэвэрлэх







52. Шинэ Үндсэн хуулийн дагуу 1992 оны 6 дугаар сард бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгууль 2 дахь удаагаа явагдав. Энэ сонгуульд аль нам ялж, хэдэн суудал авсан бэ? /1 оноо/
- A. Монгол ардын хувьсгалт нам ялж, 70 суудал
  - B. Монголын социал демократ нам ялж, 50 суудал
  - C. Монгол ардын хувьсгалт нам ялж, 50 суудал
  - D. Монголын уламжлалын нэгдсэн нам ялж, 1 суудал
  - E. Ардчилсан нам ялж, 50 суудал
53. Хэдэн онд “Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ойг тэмдэглэсэн бэ? /1 оноо/
- A. 1995 онд      B. 1994 онд      C. 1980 онд      D. 1990 онд      E. 1985 онд
54. Ардчилсан хувьсгалын дараагаар түүх судлалын шинэчлэл эрчимтэй өрнөж, олон арван түүхийн бүтээл гарч байсан бөгөөд судалгааны түвшинд бичигдэж, 2003 онд нийтийн хүртээл болсон бүтээл аль нь вэ? /2 оноо/
- A. Монголын түүхийн дээж бичиг
  - B. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир
  - C. Монгол улсын түүх 5 боть
  - D. Монголын нууц товчоо
  - E. Монголын товч түүх
55. 2002 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль нь вэ? /1 оноо/
- A. Японы ерөнхий сайд Тошкү Кайфу айлчлав.
  - B. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн К.Аннан айлчлав.
  - C. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.
  - D. ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин айлчлав.
  - E. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.
56. Хүний эрх, эрх чөлөөг хангаж үндсэн хуульд байдлыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрөө бэхжүүлж улс төрийн тогтвортой байдлыг хангах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ? /1 оноо/
- A. Хүний аюулгүй байдлыг хангах
  - B. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах
  - C. Дотоод аюулгүй байдлыг хангах
  - D. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
  - E. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах



**ХОЁРДУГААР ХЭСЭГ**

**Санамж:** Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо  
**Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.**

2.1 Монголын өвөг түүхийн үед холбогдох нээлтүүдийг хамрах үетэй нь зөв тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. **/1 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/**

/6 оноо/

- |                           |                           |
|---------------------------|---------------------------|
| a. Палеолитын доод үе     | 1. Нум сум                |
| b. Палеолитын дунд үе     | 2. Нүүдлийн мал аж ахуй   |
| c. Палеолитын дээд үе     | 3. Үйлдвэрлэх аж ахуй     |
| d. Мезолит                | 4. Үлдэц цуулдас          |
| e. Неолит                 | 5. Гоёл чимэглэл          |
| f. Хүрэл төмрийн түрүү үе | 6. Зүймэл зэвсэг буюу жад |
|                           | 7. Төмөр дөрөө            |

2.2 Дараах түүхэн үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу.

/6 оноо/

- |                                   |            |
|-----------------------------------|------------|
| a. Дөрвөлжин бичиг зохиогдов.     | 1. 1256 он |
| b. Хубилай хаан суув.             | 2. 1242 он |
| c. Алтан Ордны улс байгуулагдав.  | 3. 1260 он |
| d. Ил хаант улс байгуулагдав.     | 4. 1221 он |
| e. Цагадайн улс байгуулагдав.     | 5. 1271 он |
| f. Хубилай улсаа Юань гэж нэрлэв. | 6. 1269 он |

2.3 Монголын хаант улсуудын үеийн түүхэн зүтгэлтнүүдийг хамаарах ойлголттой нь зөв харгалзуулна уу.

/6 оноо/

- |                         |                                      |
|-------------------------|--------------------------------------|
| a. Лигдэн хаан          | 1. Цорос аймгийн толгойлогч          |
| b. Шолой Уваш           | 2. Хошуудын хаант улсыг байгуулсан.  |
| c. Галдан бошогт        | 3. Халхын томоохон язгууртан         |
| d. Төрбайх Гүүш хан     | 4. Хотгойдын улсыг байгуулсан        |
| e. Цогт хунтайж         | 5. Зүүнгарын хаант улсыг байгуулсан. |
| f. Эрдэнэбаатар хунтайж | 6. Алтан ургийн сүүлчийн хаан        |

2.4 1921 оны хувьсгалын түүхэн гол үйл явдлуудыг зөв харгалзуулна уу.

/6 оноо/

- |                         |   |
|-------------------------|---|
| a. 1920 оны 10 сарын 02 | 1. Богдыг хэмжээт цаазат хаанаар өргөмжлөв.             |
| b. 1921 оны 03 сарын 13 | 2. Монгол цэрэг Алтанбулагаас Нийслэл хүрээ рүү хөдлөв. |
| c. 1921 оны 03 сарын 18 | 3. Монгол цэргийн гол хүч Нийслэл хүрээнд ирэв.         |
| d. 1921 оны 06 сарын 30 | 4. Ардын түр засгийн газар байгуулагдав.                |
| e. 1921 оны 07 сарын 08 | 5. Хиагтыг гамин цэргээс чөлөөлөв.                      |
| f. 1921 оны 07 сарын 11 | 6. "Азийн морин дивиз" Монголд цөмрөн орж ирэв.         |

